

**Хуулиар тусгайлан дүрэм, журам батлуулахаар эрх олгогдсон заалтуудын хэрэгжилт**

**(2018 оны I улирлын байдлаар)**

№	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар	Заалт	Хэрэг-жүүлэх байгууллага	Хэрэгжилтийн байдал			Тайлбар
				Газруудаас ирсэн биелэлт	ХШУДАГ-ын үнэлгээ		
<b>1.Монгол улсын хууль</b>							
1	Авто замын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.05.11	8.6.“Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”-ыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Авто замын норм, нормативын сангийн ажиллах журмын төслийг боловсруулж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн төв, "Монгол авто замчдын холбоо" ТББ-аас уг журмын төсөлд ирүүлсэн саналыг аваад байна. Бүх талуудын оролцоог хангах үүднээс Монголын авто замчдын холбоотой хамтран 2017 оны 11 дүгээр сарын 27-ний өдөр журмын төслүүдэд санал авах хэлэлцүүлэг зохион байгуулав.	30	30	
			БТГ		30		
		9.1.Засгийн газар авто замын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.8.тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам батлах.	АЗБХЗГ	“Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох журам” ЗТБХБ-ын сайдын 2010.02.22-ны №47 тушаал Бүртгэл 2010.03.05 №3115  Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн анхдугаар хурлыг 2017.08.16-ны өдөр хийж, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх хүнд даацын авто замын барих, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор гаргаж байсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг гишүүдэд тараасан. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу дахин боловсруулан санал авахаар гишүүдэд хүргүүлж, яамны болон МАЗХ-ны цахим хуудсанд байршуулсан.	100	100	
		10.1.Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.2.авто замын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох журам баталж, хэрэгжүүлэх;	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулж дууссан. Журмыг батлуулах тушаалын төсөлд санал авч байна.	70	70	
		ТЗУГ	70				
		10.1.7.тусгай зориулалтын авто зам барих, засварлах, ашиглахтай холбоотой журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах;	АЗБХЗГ	Журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн анхдугаар хурлыг 2017.08.16-ны өдөр хийж, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх хүнд даацын авто замын барих, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор гаргаж байсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг гишүүдэд тараасан. ЗТБХБ-ын сайдын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 159 дүгээр тушаалаар батлагдсан "Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто зам барих ашиглах засвар арчлалт хийх түр журам"-аас санаа авч холбогдох дүрэм, журам хуульд нийцүүлэн журмын төслийг боловсруулан нэгтгэн ярилцахаар тохирсон. Ажлын хэсэг 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 11 цагт ЗТХЯ-нд хуралдаж, журмын төслийг дахин хянан боловсруулах шийдвэр гарсны дагуу журмын төсөл дээр дахин ажиллаж байна.Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн зөвлөмжийн дагуу дахин боловсруулан санал авахаар гишүүдэд хүргүүлж, яамны болон МАЗХ-ны цахим хуудсанд байршуулсан.	30	30	
		12.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга авто замын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.6.нийслэлийн авто замын ажлыг санхүүжүүлэх, барих, ашиглах, засах, арчлах, талаар журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хэрэгжүүлэх;	Нийслэл	биелэлт ирүүлээгүй.	0	0	
		19.3.Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	"Зам, замын байгууламжийн ТЭЗҮ-ийн судалгаа, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, хүлээн авах журам"-ыг 2016.12.20-ны өдрийн ЗТХЯ-ны ТНБД-ын №210 тушаалаар баталсан. Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.	30	30	
		20.10.Магадлашгүй ажлын зардлыг тооцож олгох журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.	30		

Засгийн газрын гишүүн хамтран батална.	БТГ	Магадлашгүй ажлын зардлыг тооцож олгох журмыг боловсруулах ажлын хэсэг ТНБД-ын 2017 оны 6-р сарын 23-ны 191 тоот тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Одоо мөрдөгдөж байгаа журам нь зохицуулалтын хувьд шаардлага хангаж байгаа тул шинээр журам боловсруулах шаардлагагүй гэж Ажлын хэсгийн зүгээс үзсэн.	30	30	
21.2.Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХШУДАГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмын ажлын хэсэг 2017 оны 09 дүгээр сарын 07-нд анхны хурлыг хийсэн. Журмын төсөлд ажлын хэсгийн гишүүдийн саналыг авч нэгтгэх ажил хийгдэж байна. Мөн тус журмыг FIDIC буюу олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос санал болгодог олон улсын гэрээтэй нийцүүлэх судалгааны ажлыг гүйцэтгэж байна.	30	30	
22.8.Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх норм, норматив болон журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах	30	30	
	БТГ	Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх норм, норматив болон журмыг боловсруулах ажлын хэсэг ТНБД-ын 2017 оны 6-р сарын 23-ны 191 тоот тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Журмыг боловсруулж байна.	30		
24.7.Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмыг Засгийн газар батална.	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.	30	30	
	БТГ	Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмыг боловсруулах ажлын хэсэг ТНБД-ын 2017 оны 6-р сарын 23-ны 191 тоот тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Журмыг боловсруулж байна.	30		
26.2.Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.	30	30	
27.4.Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан журмын төслийг боловсруулж, холбогдох саналуудыг авсан. Ирүүлсэн саналуудыг нэгтгэн Ажлын хэсгээр хэлэлцүүлж, батлуулахаар ажиллаж байна.	30	30	
	Нийслэл		30		
28.3.Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	Журмын төслийг боловсруулж, холбогдох газар, хэлтэс, ТББ-уудаас санал авч, ирүүлсэн саналуудыг нэгтгэн Ажлын хэсгээр хэлэлцүүлж, төслийг Сайдаар батлуулсан. Албажуулах шатанд явж байна.	70	70	
	ХШУДАГ		70		
30.2.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	“Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам” Засгийн газрын 2011.04.06-ны №106 тогтоолоор баталсан.  Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.	100	100	
30.3.Нийслэл, орон нутгийн чанартай болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.	Нийслэл	биелэлт ирүүлээгүй.	0	0	
31.2.Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	“Автозам, замын байгууламжийг хаах, чиглэл өөрчлөх, тээврийн хэрэгслийн тэнхлэгийн даацад хязгаарлалт хийх журам” ЗТБХБ-ын сайдын 2010.03.23. №80 тушаалаар батлагдсан. /ХЗЯ-ны бүртгэл 2010.04.12 №3127/ Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.	100	100	

		33.2.Авто зам, замын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагаас гадна мэргэжилтэй хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг илтгэх нэмэлт шаардлагыг тавих бөгөөд энэ талаархи журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АЗБХЗГ	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 тоот тушаалаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2 удаа хуралдсан бөгөөд холбогдох судалгааны ажлыг хийж гишүүдийн саналыг нэгтгэн журмын төсөлд тусгасан. Журам батлах тухай сайдын тушаалын төсөлд холбогдох газруудаас санал авч байна.	70	70	
2	Авто тээврийн тухай хууль	5.1.3.Автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, автотээврийн улсын хяналтын дүрмийг батлах	ХШУДАГ	Тус дүрмийг "Хяналтын тухай хууль" батлагдсаны дараа батлах тул одоогийн байдлаар Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм үйлчилж байна.	100	100	
		6.1. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.4. тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;	АТБХЗГ	Троллейбусны техник ашиглалтын дүрэм тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах" тухай 1999.04.14-ны өдрийн ДБХ-ийн сайд, Нийслэлийн засаг даргын хамтарсан №89А/55 тушаал 1999.04.23 №1392 Жишиг норм батлах тухай Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм-ДБЯ 2004.01.29 №19. Бүртгэл 2004.04.06 №2358 Дүрэм батлах тухай Аймаг, нийслэлийн Тээвэр зохицуулалтын албаны үлгэрчилсэн дүрэм ДБС 2000.12.11 №115. Бүртгэл 2000.12.21 №1568 Журам норм батлах тухай Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, таних ба энгэрийн тэмдэгний загвар, түүнийг хэрэглэх журам, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааны норм, Автотээврийн хяналтын улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэхэд ашиглах техник хэрэгсэл, түүнийг хэрэглэх журам ЗТБХБЯ 2011.10.10 №270 Улсын бүртгэлд бүртгэгдээгүй. Автотээврийн жишиг тариф шинэчлэн батлах тухай /Тээвэрлэлтийн зай, ачааны төрлөөс хамааруулж зорчигч, ачаа тээвэрлэлтийн жишиг тарифыг батлах/ ЗТЯ 2013.07.10 №162 Улсын бүртгэлд бүртгэгдээгүй. Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нөхцөл шаардлагын тухай журам, гэрчилгээний загвар, гэрээний загвар – ЗТЯ 2013.08.01 №169 Улсын бүртгэлд бүртгэгдээгүй. Журам батлах тухай /Авто пүү ашиглах журам/ ЗТЯ 2014.05.06 №109 Улсын бүртгэлд бүртгэгдээгүй.	100	100	ХЗДХЯ-ны бүртгэлд №2358, №1568 байхгүй.
		9.2. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АТБХЗГ	"Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам" - ЗТБХБЯ 2009.07.22 №188. Бүртгэл 2009.09.01 №3072 Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам- ЗТЯ 2015.12.09 №334. Бүртгэгдээгүй Дүрэм батлах тухай /Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм/ ЗТБХБЯ 2010.01.12 №06. Бүртгэл 2009.08.13 №3071	100	100	ХЗДХЯ-д бүртгүүлэх
		15.1. Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх болон автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тусгай зөвшөөрөл олгоно	АТБХЗГ	"Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нөхцөл шаардлагын тухай" ЗТСайдын 2013.08.01 №169 тушаал, "Журам батлах тухай" Улсын бүртгэлд бүртгэгдээгүй. Журам шинэчлэн батлах тухай /Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам"-ыг нэгдүгээр, "Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар/ Зам, тээврийн сайдын 2013.10.21-ний №232. Бүртгэл 2014.01.06 № 3422	100	100	

16.1. Автотээврийн хэрэгслээр зорчих тасалбар, ачааны дагалдах хуудас зэрэг тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АТБХЗГ	Автотээврийн хэрэгслээр зорчих тасалбар, ачааны дагалдах хуудас зэрэг тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам ЗТБХБ-ын сайдын 2011.11.03-ны өдрийн №301 тушаал 2011.11.18 №3290 Журам батлах тухай /Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, тээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар батлах/ ЗТЯ 2012.10.29 №59 2012.11.26 №3346	100	100	
17.5.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АТБХЗГ	“Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам” Зам, тээврийн сайдын 2013.01.21-ны №232 тушаал. 2014.01.06 №3422	100	100	
17.1.2.Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АТБХЗГ	“Журам батлах тухай-“Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг нэгдүгээр, Тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварыг хоёрдугаар, бүртгэлийн маягтыг гуравдугаар, явуулын дугаарын загварыг дөрөвдүгээр хавсралтаар” Зам, тээврийн сайдын 2012.10.29 -ны №59 тушаал. Бүртгэл 2012.11.26 № 3346 “Тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварыг шинэчлэн батлах тухай” Зам, тээврийн сайдын 2016.05.04-ний №115 тушаал. Бүртгэл 2016.06.16 № 3646	100	100	
18.1. Автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон улсын стандартыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн стандартчиллын төв байгууллага батална.	БТГ	СХЗГ-тай хамтран дараах стандартуудыг батлаад байна. Үүнд: • Техникийн найдварт ажиллагаа, түүний нормчлогдох үзүүлэлтүүдийг шалгах, тодорхойлох аргууд. Ерөнхий шаардлага. MNS 3990:1987 • Газар шорооны ажлын машин-ашиглалт ба засвар үйлчилгээ. Механик бэлтгэх сургалт MNS ISO 4653:1998 • Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. MNS 4410:2002 • Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар.Ерөнхий шаардлага. MNS 5011:2003 • Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд MNS 4599:2003 • Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4599:2003 • Ачааны машин ба чиргүүлийн хэрэгсэл. Суудлын автомашины чиргүүл - сач-500 техникийн ерөнхий шаардлага. MNS 5394 - 2004 • Автотээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал, Ерөнхий шаардлага • MNS 4470:2005 • Автотээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал, Ерөнхий шаардлага MNS 4470:2005 • Авто үйлчилгээ - Ангилал, Ерөнхий шаардлага. MNS 5025:2010 • Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800 маркийн троллейбус угсрах, ашиглах- Үндсэн параметр ба техникийн ерөнхий шаардлага MNS 5773:2007 • Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800F загварын дуобус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6225:2010 • Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800F загварын дуобус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6225:2010 • Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 6278: 2011 • Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл. J-800 маркийн автобус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6310:2012 • Авто тээврийн хэрэгсэл. Хоёр дугуйтай мопед болон мотоциклын хэмжээс. Нэр томъёо ба тодорхойлолт MNS ISO 6725:2016 • Мотоциклын резин дугуй ба обуд (метрийн цуврал). 2-р хэсэг: Резин дугуйны хэмжээ ба даац MNS ISO 5751-2:2016 Автозамын тээврийн хэрэгсэл. Их гэрлийн цацрагийн тусгалыг хэмжих төхөөрөмж MNS ISO 10604:2015	100	100	
19.2.Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалт авах, үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загварыг автотээврийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	АТБХЗГ	“Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”, “Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам” Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010.05.07-ны №161/229 тушаал 2010.05.21 №3154 “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн мэргэжлийн үнэмлэхний загвар” Зам, тээврийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2014.02.10-ны өдрийн №25/А/30 тушаал	100	100	ХЗДХЯ-д бүртгүүлэх
19.2.Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	АТБХЗГ	“Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам” ЗТ-ийн сайдын 2016.04.12-ны өдрийн №90 тушаал. Бүртгэл 2016.04.26 №3633	100	100	

3	Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль	5.1.Монгол Улсын Засгийн газраас агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмыг тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавина	АТБХЗХ	"Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журам" Засгийн газрын 2007.12.29-ны өдрийн №358 тогтоол. Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2018.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. "Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмыг шинэчлэн батлах тухай" ЗГ-ын шийдвэр албажих шатанд байна.	100	100	
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	5.3.Автотээврийн болон өөрөө ачигч хэрэгслийн нэгж километр зайд явахад ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээгээр нь бүлэглэх ангиллыг суудлын автомашины хөдөлгүүрийн багтаамж, автобус, ачааны машины даацаас хамааруулан тогтоох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.	АТБХЗГ	"Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011.03.07-ны өдрийн №А-63/67 хамтарсан тушаал 2011.03.15 №3228	100	100	
5	Агаарын тухай хууль	17.2.2.агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэмжилтийн аргачлалыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;	АТБХЗГ	Олон улсын байгууллагын "Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн хамгаалал. Аюулгүй байдал" ангиллын "Агаарын чанар" бүлгийн "Тээврийн хэрэгслийн шатсан хийн бохирдол" дэд бүлэгт хамрагдах 12 ширхэг ISO стандартыг нутагшуулах ажлыг хамтран зохион байгуулсан. 2014 оны агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хаягдалтай холбогдох 17 стандартыг Стандарт хэмжил зүйн газраар батлуулсан. o Автотээврийн хэрэгсэл. Техникийн хяналт болон үйлчилгээний үед ажилласан хийн хорт бодисын агууламжийг хэмжих аргууд MNS ISO 3929:2014 o Тээврийн хэрэгслийн ажилласан хий дэх хорт бодисыг хэмжих багаж. Хэмжил зүйн болон техникийн шаардлагууд, туршилт явуулах болон хэмжил зүйн хяналт MNS ISO/PAS 3930:2014 o Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтат хөдөлгүүр. Ажилласан хий дэх хорт бодисын агууламжийг хэмжих. 1-р хэсэг: Туршилтын стэнд дээр ажилласан хий дэх тоосонцор болон хий байдалтай хорт бодисыг хэмжих MNS ISO 8178-1:2014 o Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтат хөдөлгүүр. Ажилласан хийн хорт бодисын агууламжийг хэмжих. 2-р хэсэг: Ажлын нөхцөлд ажилласан хий дэх тоосонцор болон хийн байдалтай хорт бодисыг хэмжих MNS ISO 8178-2:2014 o Давших буцах хөдөлгөөнт дотоод шаталтын хөдөлгүүр. Ажилласан хий дэх хорт бодисын агууламжийг хэмжих. 3-р хэсэг: Ажилласан хийн тортогжилтыг тогтонги горимд хэмжих арга ба тодорхойлолт MNS ISO 8178-3:2014 o Автозамын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 1-р хэсэг: Ерөнхий мэдээлэл болон асуудлыг шийдвэрлэх тохиолдол, тодорхойлолт MNS ISO 15031-1:2014 o Автозамын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 2-р хэсэг: Нэр томьёо, тодорхойлолт, товчлол ба товчилсон үгийн тайлбар MNS ISO 15031-2:2014 o Автозамын тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэл болон ажилласан хийн хорт бодисын агууламжид нөлөөлдөг системүүдийг оношлох нэмэлт төхөөрөмжийн харилцан холболт. 3-р хэсэг: Оношлогооны	100	100	
		17.2.4.Автобензин, дизель түлш, шингэрүүлсэн шатдаг хий зэрэг түлш шатахууны стандартыг автотээврийн болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлуулна	АТБХЗГ	Түлш шатахууны дараах стандартуудыг СХҮЗ-ийн тогтоолоор батлуулсан. Үүнд: • Шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хий – Автотээврийн түлш - Техникийн шаардлага MNS 5084 - 2001 • Дизелийн түлш. Техникийн шаардлага MNS 0216 - 2006 • Дотоод шаталтат хөдөлгүүрийн түлш Автобензин. Техникийн шаардлага MNS 0217 - 2006 • Тийрэлтэт хөдөлгүүрийн түлш. ТС-1. Техникийн шаардлага MNS 5677 - 2006 • Биодизелийн түлш. техникийн шаардлага MNS 6381 - 2013	100	100	

6	Жолоочийн даатгалын тухай хууль	2.3.Энэ хуулийн 22.1.2, 22.1.4-т заасан эх үүсвэрийг Жолоочийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 22.1.4.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь; 22.1.2.энэ хуулийн 28.1-д заасан орлогын 50 хувь; /Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч уг буруутай этгээдэд дараах захиргааны хариуцлага ногдуулна/	АТБХЗГ	"Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх журам" Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013.01.13-ны өдрийн №20/19 хамтарсан тушаал 2013.02.06 №3367	100	100	
7	Далай ашиглах тухай хууль	9.3. Хөлөг онгоц бүртгэх журмыг Засгийн газар батална.	ТЗДТБХЗГ	"Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам" Засгийн газрын 2003.01.08-ны өдрийн №3 тогтоол	100	100	
8	Иргэний нисэхийн тухай хууль	7.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.9. иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг батлах;	АТБХЗХ	Иргэний нисэхийн дараах багц дүрмүүдээр иргэний нисэхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулж байна. Үүнд: 1. Агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх ба нислэгийн бусад үйл ажиллагаа: • инд-115 сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.05.14 №3145 • инд-119 агаарын тээвэрлэгч гэрчилгээжүүлэлт /air operator certification/ Бүртгэл 2010.04.30 №3139 • инд-121 агаарын тээврийн үйл ажиллагаа – багтаамж ихтэй онгоц Бүртгэл 2010.10.28 №3194 • инд-121 агаарын тээврийн үйл ажиллагаа – дунд онгоц Бүртгэл 2009.05.13 №3028 • инд-129 гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх Бүртгэл 2010.05.14 №3145 • инд-131 агаарын хөлгийн түрээс Бүртгэл 2010.05.14 №3145 • инд-133 нисдэг тэрэгний дүүжин тээвэрлэлт Бүртгэл 2010.05.14 №3145 • инд-135 агаарын тээврийн үйл ажиллагаа – багтаамж багатай онгоц, нисдэг тэрэг Бүртгэл №3249 • инд-137 хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.05.14 №3145 2. Аэродром • инд-139 аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.04.12 №3126 • инд-157 аэродром байгуулах, өөрчлөх, ашиглалтаас хасах Бүртгэл 2010.05.14 №3145 3.Байгууллага • инд-140 нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх Бүртгэл 2010.10.28 №3194 • инд-141 иргэний нисэхийн сургалтын байгууллага, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.04.30 №3137 • инд-144 нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.05.14 №3145 • инд-145 агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.04.30 №3137 • инд-148 агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги үйлдвэрлэгч байгууллагыг гэрчилгээжүүлэх Бүртгэл 2010.06.27 №3169 • инд-149 нисэх клуб – гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.05.14 №3145 • инд-337 ачаа тээвэр зуучлалын байгууллага, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.05.14 №3145 1. Гэрчилгээжсэн агаарын навигацийн үйлчилгээний байгууллагууд • инд-138 эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа Бүртгэл 2010.04.30 №3137 • инд-171 агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага, үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.04.01 №3122 • инд-172 нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.04.01 №3122 • инд-173 нислэгийн журмын үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт Бүртгэл 2010.10.28 №3194	100	100	
		7.1.12. нислэг-техникийн осол, зөрчлийн Ерөнхий шинжээч /цаашид "Ерөнхий шинжээч" гэх/, шинжээчийг томилж чөлөөлөх, Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийг батлах;	АТБХЗХ	ИНД-203 Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах дүрэм Бүртгэл 2010.04.30 №3137 ИНД-13 Зөрчлийг шалгах дүрэм Бүртгэл 2010.10.28 №3194	100	100	

		11.2.14. иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журмыг тогтоох;	АТБХЗХ	ИНД-341: Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох дүрмийг Зам, тээврийн сайдын 2015 оны 320 дугаар тогтоолоор батлуулж, Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр 2015 оны 12 дугаар сарны 25-ны 03/5658 дугаар албан тоотой хүргүүлсэн. Хууль зүйн яамнаас бүртгэхээс татгалзсан хариуг 2016 оны 1 дүгээр сарын 22-ны 6/361 дүгээр албан бичгээр ирүүлсний дагуу ИНД-341-г зарим нэг нэмэлт, өөрчлөлтийг хийж ирүүлэх тухай ИНЕГ-т 2016 оны 01 дүгээр сарын 29-ны 08/400 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Уг дүрмийн шинэчилсэн төслийг 5-р сард багтаан ирүүлэх тухай 2016.05.09-ний 08/1964 тоот албан бичгийг ИНЕГ-т дахин хүргүүлсэн. "Иргэний нисэхийн тухай" хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу "Иргэний нисэхийн багц дүрэм"-ийг Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2018 оны 2 дугаар хагаст шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.	70	70	
9	Цөмийн энергийн тухай	39.3. Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн газар батална.	АТБХЗГ	1989 онд тухайн үеийн БНМАУ-ын Улсын ариун цэврийн ерөнхий байцаагчийн баталсан "Цацраг идэвхт бодис тээвэрлэх аюулгүйн дүрэм" нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Цөмийн энергийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т "Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн газар батална" гэж заасны дагуу Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас "Санал авах тухай" 04/691 албан бичиг ирүүлсний дагуу "Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журам"-ын төсөлд тус яамны 2015.12.09-ны өдрийн 06/5561 тоот албан бичгээр холбогдох саналыг хүргүүлсэн.	100	100	ХЗДХЯ-д бүртгэлгүй
10	Төмөр замын тээврийн тухай хууль	10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.3.төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг батлах; 15.1.Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр дараахь журмыг тогтооно: /16 журам/ 15.1.1.төмөр замын техник ашиглалтын журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын техник ашиглалтын дүрэм" /"Төмөр замын техник ашиглалтын дүрэм"-ийг нэгдүгээр, "Төмөр замын дохиоллын журам"-ыг хоёрдугаар, "Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам"-ыг гуравдугаар хавсралтаар/ ЗТАЖ-ын сайдын 2008.04.04-ны №63 тушаал 2008.04.11 №2897	100	100	
		10.1.13.төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг Тагнуулын ерөнхий газартай хамтран батлах;	ТЗДТБХЗГ	"Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, буулгах, хадгалах журам" ЗТБХБЯ ТЕГ 2010.04.19 №130/190 Бүртгэл 2010.05.19 №3149	100	100	
		10.1.14.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтны зорчих тусгай галт тэрэгний аялах журмыг Тагнуулын ерөнхий газартай зөвшилцөн батлах;	ТЗДТБХЗГ	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтны зорчих "Тусгай галт тэрэгний аялах журам" Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын №140 тушаал	100	100	ХЗДХЯ-д бүртгэлгүй
		10.1.17. тусгай тээвэрлэлт болон цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагатай зөвшилцөн батлах;	ТЗДТБХЗГ	"Цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журам" Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Батлан хамгаалахын сайдын 2011.06.08-ны №159/14 хамтарсан тушаал	100	100	ХЗДХЯ-д бүртгэлгүй
		15.1.2.төмөр замын дохиолол холбооны журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын дохиоллын журам" Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2008.04.04-ний №68 тушаал	100	100	ХЗДХЯ-д бүртгэлгүй
		15.1.3.галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;	ТЗДТБХЗГ	"Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам" Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2008.04.04-ний №68 тушаал	100	100	ХЗДХЯ-д бүртгэлгүй
		15.1.4.төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах журам" ЗТБХБЯ 2010.06.17 №217 Бүртгэл 2010.08.16 №3179 Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан сүйрэл, осол, гологдлыг бүртгэх, мэдээлэх журам ГТХЗНТ-ийн захирлын тушаал 2013.08.07 №а/50	100	100	
		15.1.5.төмөр замаар ачаа тээвэрлэх журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм" ЗТАЖЯ 2008.05.27 №88 Бүртгэл 2008.06.04 №2919	100	100	
		15.1.6.төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм" ЗТАЖЯ 2008.05.27 №88 Бүртгэл 2008.06.04 №2919	100	100	

15.1.7.төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам" /Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам"-ыг нэгдүгээр, "Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах журам"-ыг хоёрдугаар, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын болон үйл ажиллагааны гэрчилгээний тодорхойлолт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар/ ЗТЯ 2012.12.28 №120 2013.01.21 №3360. ЗТХ-ийн сайдын 2017.12.01-ний №250 тушаал. -Тээвэр зуучлал ерөнхий шаардлага. MNS 5523:2013 2011.03.15 №3229	100	100	ХЗДХЯ-д бүртгүүлэх
15.1.8.галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам;	ТЗДТБХЗГ	"Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам" ЗТЯ 2014.09.18 №216 Бүртгэл 2014.09.29 №3482	100	100	
15.1.9.суурь бүтэц ашиглуулах журам, тариф тогтоох аргачлал;	ТЗДТБХЗГ	"Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох журам" ЗТЯ 2015.07.03 №188 Бүртгэл 2015.08.07 №3546 "Суурь бүтэц ашиглуулах журам" ЗТХ-ийн сайдын 2017.07.06-ны №140 Бүртгэл 2017.09.13-ны №3787	100	100	
15.1.10.төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам" /Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам"-ыг нэгдүгээр, "Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах журам"-ыг хоёрдугаар, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар, "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын болон үйл ажиллагааны гэрчилгээний тодорхойлолт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар/ ЗТЯ 2012.12.28 №120 2013.01.21 №3360. ЗТХ-ийн сайдын 2017.12.01-ний №250 тушаал.	100	100	ХЗДХЯ-д бүртгүүлэх
15.1.11.төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүй бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, нэвтрэх журам" ЗТХЯ 2017.10.10 №205 Бүртгэл 2017.10.24 №3801 "Төмөр замын аюултай бүсийн дэглэм" ТЗГ-ын 2010.01.25-ны №6 Бүртгэл 2010.02.01№3109	100	100	
15.1.12.Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам;	ТЗДТБХЗГ	Журам шинэчлэн батлах тухай /МУ-ын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл/ ЗТЯ 2014.10.14 №234. Бүртгэл 2014.12.05 №3502	100	100	
15.1.13.галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл;	ТЗДТБХЗГ	"Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам" Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2008.05.27-ны №88 тушаал Бүртгэл 2008.06.04 №2919	100	100	
15.1.14.холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт явуулах, мэргэжлийн шалгалт авах журам;	ТЗДТБХЗГ	"Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт явуулах, мэргэжлийн шалгалт авах журам" Боловсруулж, Боловсрол үнэлгээний төвд хүргүүлсэн. Гэвч Боловсролын тухай хуультай зөрчилдөж байна, салбар бүрийн мэргэжилтэй ажилтан бэлтгэхтэй холбоотой журам гаргах боломжгүй гэсэн хариу өгсөн тул батлаагүй. ЗТХС-ын 2018.01.05-ны №03 тушаалаар ажлын хэсэг байгуулагдан боловсруулж байна.	30	30	
15.1.15.суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар;	ТЗДТБХЗГ	"Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загвар" ЗТБХБ-ны сайдын 2011.05.20-ны №151 тушаал "Суурь бүтэц ашиглуулах журам" ЗТХ-ийн сайдын 2017.07.06-ны №140 Бүртгэл 2017.09.13-ны №3787	100	100	ХЗДХЯ-д бүртгүүлэх
15.1.16.төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам.	ТЗДТБХЗГ	Журам батлах тухай Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам ЗТЯ 2014.10.06 №225. Бүртгэл 2014.12.08 №3507	100	100	
25.4.Төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь тэмдэг, дугаар бүхий хатуу тооцоот багаж, хэрэгсэлтэй байх бөгөөд түүний жагсаалт, ашиглах болон хүлээлцэх журмыг төрийн захиргааны төв байгууллага тогтоож, жагсаалтыг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлнэ.	ТЗДТБХЗГ	"Хатуу тооцоот багаж хэрэгслийг ашиглах болон хүлээлцэх журам" ЗТХ-ийн сайдын 2017.07.28-ны өдрийн №146 тушаал Бүртгэл 2017.09.13 №3789	100	100	



		26.1.Аюултай ачааны үйлдвэрлэл, хадгалалт, ачилт, буулгалт, дамжуулалт хийж байгаа газрын барилга байгууламжууд /цаашид "аюултай байгууламжууд" гэх/ нь суурь бүтцээс аюулгүй ажиллагааг хангахуйц зайд байрлах бөгөөд аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	ТЗДТБХЗГ	Аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцлийг тодорхойлох журам Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.08.02-ны №148 Бүртгэл 2017.09.13 №3790	100	100	
		28.1.Төмөр замын гармыг нээх, ашиглах, хаах, хамгаалалтын дохио, тэмдэг, төхөөрөмжөөр тоноглох, засварлах, түүнчлэн төмөр замын гармын зэрэглэл тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага цагдаагийн байгууллагатай зөвшилцөн батална.	ТЗДТБХЗГ	"Төмөр замын гарам ашиглах журам" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 141 дүгээр тушаалаар батлуулж, Бүртгэл 2017.09.13 №3788	100	100	
11	Улсын нисэхийн тухай хууль	11.2.Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан журмаар хэрэгжүүлнэ.	АТБХЗХ	Журам батлах тухай /Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах, Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах/ ЗТБХБЯ, БХЯ 2007.11.08 №390/180 Бүртгэл 2008.12.05 №2972	100	100	
		13.2.Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах журмыг батлан хамгаалах болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	АТБХЗХ	Журам батлах тухай /Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах, Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах/ ЗТБХБЯ, БХЯ 2007.11.08 №390/180 2008.12.05 №2972	100	100	
12	Усан замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.05.25	5.1.Засгийн газар усан замын тээврийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.3.усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх, усан замын тээврийн улсын хяналтын дүрмийг батлах;	ТЗДТБХЗГ	Хуулийн энэхүү заалтыг МХЕГ хэрэгжүүлэх ба Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар "Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм"-ийг баталсан бөгөөд Усан замын тээврийн тухай хуулийн 18 дугаар зүйлд "Усан замын тээврийн болон усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдалд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагч... Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ" гэж заасан.	100	100	
		5.1.4.импортоор оруулж ирэх усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах эрүүл ахуй, халдвар судлал, хорио цээрийн шаардлагыг тогтоосон журам батлах;	ТЗДТБХЗГ	Хуулийн энэхүү заалтыг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио, цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, бусад холбогдох хууль, мөн Монгол Улсын нэгдэн орсон "Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцлийг уялдуулах тухай олон улсын конвенцийн дагуу МХЕГ--ын Хилийн хяналтын алба хэрэгжүүлж ажиллана.	100	100	
		6.1.Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.5.тээвэрлэлтийн үйл ажиллагаа, усан замын тээврийн хэрэгсэл, усан замын төв буудал, зогсоол, аврах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын талаар мөрдөх нийтлэг дүрэм, журам, норм, нормативыг батлах, биелэлтийг хангуулах;	ТЗДТБХЗГ	Хуулийн энэхүү заалтын дагуу 3 дүрэм, 4 журам боловсруулагдаж мөрдөгдөнө. Үүнд: 1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм; /шинээр/ 2. Усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм; /шинээр/ 3. Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм. /шинээр/ 4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам; /өөрчлөлт/ 5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам; 6. Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам; /шинээр/ 7. Усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам; /шинээр/ Мөн шинээр болон шинэчлэх журмын төслийг боловсруулж ирүүлэх тухай 02/3321 тоот албан бичгийг Далайн захиргаанд хүргүүлэн ажиллаж байна.	30	30	ХЗДХЯ-д бүртгэлгүй

		6.1.8.усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм боловсруулах, батлах;	ТЗДТБХЗГ	Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг шинээр боловсруулан Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, удирдлага, хуулийн хэлтэст хянуулан санал авч, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд-завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 263 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-нд 03/575 тоот албан бичгээр хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлийн 3861 дүгээрт бүртгүүлэв.	100	100	
		6.1.9.усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;	ТЗДТБХЗГ	Хуулийн 6.1.14.-т "гэрээний үндсэн дээр зарим чиг үүргийг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагад шилжүүлэх" гэж заасны дагуу энэхүү журмын төслийг шинээр боловсруулж ирүүлэх тухай 02/3321 тоот албан бичгийг Далайн захиргаанд хүргүүлсэн. Тус байгууллага энэ асуудлаар Боловсролын яам, Хөдөлмөрийн яам, Мэргэжлийн боловсрол, сургалтын төв зэрэг байгууллагатай уулзалт яриа хэлэлцээ, судалгаа хийж байна.	30	30	
		6.1.12.усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загварыг батлах;	ТЗДТБХЗГ	Хуульд заасан энэхүү журмыг шинээр боловсруулан төслийг ирүүлэх тухай 2017 оны 02/3321 тоот албан бичгийг Далайн захиргаанд хүргүүлсэн бөгөөд тус байгууллага журмын төсөл дээр ажиллаж байна. Энэхүү журмыг шинээр боловсруулахад их хэмжээний цаг хугацаа, тооцоо, судалгаа, мэдээлэл, материал шаардлагатай.	0	0	
		6.1.13.усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрмийг батлах;	ТЗДТБХЗГ	Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам ЗТАЖЯ 2005.02.07 №23 Улсын бүртгэл 2005.02.23 №2499 Усан замын тээврийн хяналтын зохицуулалт, аюулгүй ажиллагааны журам ЗТАЖЯ 2007.08.17 №128 Усан замын тээврийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна.	70	70	ХЗДХЯ-д бүртгэлгүй
		11.2.Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ТЗДТБХЗГ	Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийг шинээр боловсруулж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу журмын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд болох завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 263 дугаар тушаалаар батлуулж, ХЗДХЯ-нд 03/575 тоот албан бичгээр хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлийн 3861 дүгээрт бүртгүүлэв. Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам /Өөрчлөх, шинэчлэх шаардлагагүй/ ЗТАЖЯ 2006.04.05 №45 Улсын бүртгэл 2006.09.27 №2637	100	100	
		16.3.Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ТЗДТБХЗГ	Журам батлах тухай /Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам/ ЗТС, БОНХС хамтарсан тушаал 2014.06.02 №138А/208 2014.07.08 №3466 бүртгүүлсэн.	100	100	
13	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	23.4.Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	АТБХЗГ	"Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам" ЗТ-ийн сайдын 2016.04.12-ны өдрийн №90 тушаал. Бүртгэл 2016.04.26 №3633	100	100	
14	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	9.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.	АЗБХЗГ	Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага. MNS 5682 - 2006 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056 - 2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага. MNS 6055 - 2009 батлуулсан.	100	100	
		10.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандартыг тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.	АТБХЗГ	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага. MNS 5012-2011 Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага : MNS 5879 - 2012 Эдгээр стандартуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусгасан.	100	100	
15	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	13.2. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин механизм, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална.	БТГ	НӨАТ-ын тухай хуулийн 13.1.9-д заасны дагуу татвараас чөлөөлөх хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалтыг Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний 503 дугаар тогтоолоор батлуулсан.	100	100	

					100	54	54	
					90	0	0	
					70	6	4	
					50	0	0	
					30	14	10	
					10	0	0	
					0	4	4	
					Хугацаа болоогүй	0	0	
						<b>78</b>	<b>72</b>	

**83.05556**